



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.06.05 № 121 ЧАГ-САГ/2013/СТА-ЗГСНТ

Зөрчил арилгуулах тухай

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2003 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 55 дугаар захирамжаар БНХАУ-аас Монгол Улсын Засгийн газрын авсан зээлийн төслийг хэрэгжүүлэгч "Гангар" ХХК-иас 2002 оны эхний хагас жилд төлөх 816.7 сая төгрөгийн зээлийн үндсэн өр болон хүүгийн төлбөрт тус компаний шинээр барьж ашиглалтад оруулсан 851.1 сая төгрөгийн өртөгтэй 2320 м2 талбай бүхий 40 айлын сууцны тоосгон барилга /Баянзүрх дүүргийн 13 дугаар хороололд байршилтай/-ыг төрийн албан хаагчдын зориулалтаар ашиглахаар тооцож төрийн өмчид хүлээн авахыг Санхүү, эдийн засгийн сайд /хуучин нэрээр/-д зөвшөөрсөн боловч уг орон сууцыг төрийн өмчид хүлээн авч бүртгээгүй,

Уг захирамжаар хавсралтын эхний 15 хүний орон сууцны төлбөрийн 303.6 сая төгрөгийг чөлөөлж, үлдэх 547.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг СЭЗЯ-д үүрэг болгосон боловч чөлөөлөгдсөн хүмүүсийн орон сууцны төлбөрийг ямар эх үүсвэрээс тооцон гадаад зээлийн төлбөрийг барагдуулах асуудлыг тодорхой зааж өгөөгүй,

Хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу орон сууцанд орсон албан хаагчидтай 2002 оны 8 дугаар сард багтаан гэрээ байгуулахыг яам, байгууллагын удирдлагад үүрэг болгосон боловч нэр бүхий 25 хүнтэй гэрээ байгуулахаас 11 хүнтэй гэрээ байгуулсан, бусад 14 хүнтэй гэрээ байгуулаагүй,

Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 32 дугаар Захирамжаар ямар нэгэн эрхийн актын үндэслэлгүйгээр дахин нэр бүхий 10 хүн /үүнээс нэр бүхий 4 хүн зээлийн гэрээ байгуулсан байсан/-ий орон сууцны анхны үнэ болох 231,482.2 мянган төгрөгийг чөлөөлсөн,

Үлдэх 15 байгууллага, хүнээс авах авлагын 316.0 сая төгрөгийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүйгээс Засгийн газрын нэгдсэн тайланд 10 жил дараалан авлагаар бүртгэгдэж ирсэн байна.

Дээрх нэр бүхий 15 хүнээс Гадаад хэргийн яамны С.Ганхуяг 3,900.0 мянга, Дэд бүтцийн яамны Мэдээлэл холбооны технологийн бодлого зохицуулалтын газрын орлогч дарга Т.Нармандах 2,000.0 мянга, НХХЯ-ны Ц.Амартөгс 4,500.0 мянга, нийт 10,400.0 мянган төгрөг төлөгдсөн байна. (Хавсралт № 1)

2. Төрийн албан хаагчийн орон сууцны авлагын 33060201 тоот дансны үлдэгдлийг нотлох баримтаар тулган баталгаажуулахад нэр бүхий 10 байгууллага, хүний нэр, авлагын үлдэгдлийг зөрүүтэй бүртгэснээс дансны авлагыг 9,354,675.00 төгрөгөөр илүү дүнгээр бүртгэж тайлагнасан байна. (Хавсралт № 2)

3. Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 373 дугаар тушаалаар батлагдсан журмын хавсралт Гэрээний 2.3-д "энэхүү зээлээр авсан орон сууцыг зөвхөн төрийн албан хаагчдын орон сууцны зориулалтаар ашиглана", 4.1-д "Зээлээр олгосон орон сууцыг төрийн албан хаагч нь бусдад шилжүүлэх, зээлийн барьцаанд тавих, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх г.м өөр бусад зориулалтаар ашигласан тохиолдолд СЭЗЯ тус орон сууцыг төрийн өмчид хураан авна", 4.2-д "Төсөвт байгууллага нь зээлийн үндсэн төлбөрийг 2 жил, хүүгийн төлбөрийг 1 жил хүртэлх хугацаагаар хожимдуулсан тохиолдолд тухайн орон сууцыг хураан авах ба ашигласан хугацааны төлбөрийг улсын орлого болгоно. Хэрэв ашигласан хугацааны төлбөрийг төлөөгүй бол гэрээ байгуулсан байгууллагаас ногдуулж авна", 6.6-д "Тус гэрээ нь Дэд зээлдэгчдэд дамжуулан олгосон хөрөнгийн нийт үндсэн төлбөр болон бүх төрлийн үүрэг бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно" гэж тус тус заасан байна.

4. Хавсралтад дурдсан нэр бүхий 15 хүний орон сууцны үнэ 316,041,275.00 төгрөг, зээлийн хүү 50,567,949.00 төгрөг, торгуулийг Иргэний хуулийн 232.4-д "Анз нь торгууль, алданги гэсэн төрөлтэй байна. Анзын нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтэрч болохгүй" гэж заасныг үндэслэн 183,304,612.00 төгрөгөөр, үүнээс нэр бүхий 3 хүний зээлийн төлбөрийн 10,400,000.00 төгрөгийг хасаж тооцон улсын төсөвт төлөх төлбөрийг нийт 539,513,836.00 төгрөгөөр тооцоолсон болно. (Хавсралт № 1)

Дээрх зөрчил дутагдал нь Монгол Улсын Ерөнхий сайдын 2003 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 55 дугаар Захирамжийн 1, 3 дугаар заалт, Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 373 дугаар тушаалаар батлагдсан журмыг бүхэлд нь зөрчсөн байна.

"Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн дараах Албан шаардлагыг өгч байна.

1. Төрийн албан хаагчийн орон сууцны авлагын үлдэгдлийг Хавсралт № 1-д дурдсан нэр бүхий 15 байгууллага, хүний нэрээр нийт 539,513,836.00 төгрөгөөр шинэчлэн бүртгэж холбогдох залруулгыг хийх,

2. Хавсралт № 1-д дурдсан нэр бүхий 15 айлын 861.5 м2 талбай бүхий орон сууцыг нийт 539,513,836.00 төгрөгөөр үнэлэн Засгийн газрын авлагын бүртгэлд холбогдох байгууллага хүний нэрээр шинэчлэн бүртгэж, авлагыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2013 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг ажиллахыг Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга Т.Доржханд нарт даалгав.

АХЛАХ АУДИТОР

Г.ЮРА

УХА0122

Байгууллагын нэр	Эзэмшигчийн нэр	Гэрээ байгуулсан эсэх	Эрхийн бичгийн дугаар	Байрны дугаар	Орцны дугаар	Давхар	Хаалганы дугаар	Өрөөний тоо	Талбай м2	Нийт үнэ /төгрөгөөр/ 1м2=366,850.00	Зээлийн хүү	Торгууль /хоногийн 0.3 хувь/	Иргэний хуулийн 232-д заасны дагуу гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиар тооцсон торгууль	Гэрээний дагуу төлсөн дүн	Нийт төлөх дүн
Монгол Улсын Ерөнхий сайдын 2003 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 55 дугаар захирамжаар чөлөөлөгдсөн															
1	Өндөр настан	Дамбажав	Г3900101	39-Г	1	1	1	1	49.5	18,159,075.00					
2	Өндөр настан	Дашдэлэг	Г3900524	39-Г	2	1	24	1	49.5	18,159,075.00					
3	Завхан Улиастай	Төмөрбат	Г3900417	39-Г	1	5	17	1	49.5	18,159,075.00					
4	Зохиолч	Урианхай	Г3900313	39-Г	1	4	13	1	49.5	18,159,075.00					
5	Сувилагч	С.Алтанбагана	Г3900105	39-Г	1	2	5	1	49.5	18,159,075.00					
6	Үндсэн хуулийн цэц	С.Удвал	Г3902510	39-Б	1	3	10	2	58	21,277,300.00					
7	Үндсэн хуулийн цэц	Н.Чинбат	Г3902203	39-Б	1	1	3	2	58	21,277,300.00					
8	Усан спорт сургалтын төв	Дөрвөлжин	Г3902306	39-Б	1	2	6	2	58	21,277,300.00					
9	Хамгаалалтын алба	Б.Товуудорж	Г3902407	39-Б	1	2	7	2	58	21,277,300.00					
10	Өндөр настан	Лувсанноров	Г3902102	39-Б	1	1	2	2	58	21,277,300.00					
11	Зохиолч	З.Түмэнжаргал	Г3900940	39-Г	2	5	40	1	49.5	18,159,075.00					
12	УИХ-ын гишүүн	Ц.Өөлд	Г3902025	39-В	2	2	25	2	66.5	24,395,525.00					
13	УИХ-ын гишүүн	С.Дулам	Г3901837	39-Г	2	5	37	2	66.5	24,395,525.00					
14	СЕХ-ны дарга	Ж.Ядамсүрэн	Г3903530	39-Б	2	3	30	2	58	21,277,300.00					
15		Ц.Нямжав	Г3900628	39-Г	1	2	28	1	49.5	18,159,075.00					
	Дүн								827.5	303,568,375.00					
Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 32 дугаар захирамжаар чөлөөлөгдсөн															
16	Архангай аймаг	Ж.Нэргүй	гэрээтэй	Г3901004	39-Г	1	1	4	2	66.5	24,395,525.00				
17	Баянхонгор аймаг	Б.Чойжилсүрэн		Г3901216	39-Г	1	4	16	2	66.5	24,395,525.00				
18	Булган аймаг	М.Оюунбат	гэрээтэй	Г3901320	39-Г	1	5	20	2	66.5	24,395,525.00				
19	Дундговь аймаг	Ж.Адъяа	гэрээтэй 2003.10.16	Г3901421	39-Г	2	1	21	2	66.5	24,395,525.00				
20	Орхон аймаг	К.Даулетбай	гэрээтэй	Г3901525	39-Г	2	2	25	2	66.5	24,395,525.00				
21	Төв аймаг	М.Мэндбилэг		Г3901629	39-Г	2	3	29	2	66.5	24,395,525.00				
22	Увс аймаг	Д.Тогоо		Г3901733	39-Г	2	4	33	2	66.5	24,395,525.00				
23	ЗГХЭГ	Энхболдбаатар		Г3901108	39-Г	1	2	8	2	66.5	24,395,525.00				
24	ЗГХЭГ	Н.Эрдэнэбаатар		Г3900732	39-Г	2	3	32	1	49.5	18,159,075.00				
25	ЗГХЭГ	Г.Оюунтунгалаг		Г3900836	39-Г	2	4	36	1	49.5	18,159,075.00				
	Дүн								631.0	231,482,350.00					
11	Үндэсний аудитын газар	Ж.Батсайхан	гэрээтэй	Г3903631	39-Б	2	3	31	2	58	21,277,300.00	3,351,175.00	116,335,721.86	12,314,237.50	36,942,712.50
12	ЗГХЭГ	Өлзийбат		Г3900209	39-Г	1	3	9	1	49.5	18,159,075.00	2,961,896.46	99,286,521.24	10,560,485.73	31,681,457.19
13	Төрийн албаны зөвлөл	Чадраабал	гэрээтэй	Г3903427	39-Б	2	2	27	2	58	21,277,300.00	3,183,524.00	116,335,721.86	12,230,412.00	36,691,236.00
14	Санхүү, эдийн засгийн яам	Энх-Ариунаа		Г3903326	39-Б	2	2	26	2	58	21,277,300.00	3,400,432.33	116,335,721.86	12,338,866.16	37,016,598.49
15	Гадаад хэргийн яам	С.Ганхуяг	гэрээтэй 2003.9 сар	Г3902714	39-Б	1	4	14	2	58	21,277,300.00	3,848,320.00	116,335,721.86	12,562,810.00	3,900,000.0
16	Хууль зүй дотоод хэргийн яам	Ц.Нугармаа		Г3902815	39-Б	1	4	15	2	58	21,277,300.00	3,276,700.20	116,335,721.86	12,277,000.10	36,831,000.30
17	Байгаль орчны яам СТХ-ийн дарга	Т.Туул	гэрээтэй 2003.12.01	Г3902918	39-Б	1	5	18	2	58	21,277,300.00	3,276,700.20	116,335,721.86	12,277,000.10	36,831,000.30
18	БХЯ	Б.Эрдэнэбат		Г3903019	39-Б	1	5	19	2	58	21,277,300.00	3,400,432.33	116,335,721.86	12,338,866.16	37,016,598.49
19	БСШУЯам	Л.Цэдэвсүрэн		Г3902611	39-Б	1	3	11	2	58	21,277,300.00	3,400,432.33	116,335,721.86	12,338,866.16	37,016,598.49
20	Дэд бүтцийн яам, МХТ-ийн БЗГ-ын дарга	Т.Нармандах	гэрээтэй 2004.5.5	Г3904039	39-Б	2	5	39	2	58	21,277,300.00	3,276,700.20	116,335,721.86	12,277,000.10	2,000,000.00
21	НХХЯам	Ц.Амартөгс	гэрээтэй 2003.12.19	Г3903223	39-Б	2	1	23	2	58	21,277,300.00	3,806,815.00	116,335,721.86	12,542,057.50	4,500,000.00
22	Үйлдвэр худалдааны яам	Ш.Уранчимэг		Г3903734	39-Б	2	4	34	2	58	21,277,300.00	3,400,432.33	116,335,721.86	12,338,866.16	37,016,598.49
23	ХХААЯам	Т.Лувсанбүд		Г3903938	39-Б	2	5	38	2	58	21,277,300.00	3,400,432.33	116,335,721.86	12,338,866.16	37,016,598.49
24	ЭМЯам	Ц.Халтар	гэрээтэй 2003.7.10	Г3903835	39-Б	2	4	35	2	58	21,277,300.00	3,183,524.00	116,335,721.86	12,230,412.00	36,691,236.00
25	ТТХГазар			Г3903122	39-Б	2	1	22	2	58	21,277,300.00	3,400,432.32	116,335,721.86	12,338,866.16	37,016,598.48
	Дүн								861.5	316,041,275.0	50,567,949.0	1,727,986,627.3	183,304,612.0	10,400,000.0	539,513,836.0
	Нийт Дүн								2,320.0	851,092,000.0	50,567,949.0	1,727,986,627.3	183,304,612.0	10,400,000.0	539,513,836.0

№	Авлагын 33060201 дугаар дансанд бүргэснээр		№	Аудитаар баталгаажуулсан үлдэгдэл		Зөрүү
1	ЗГХЭГ DZ-1992-1	18,159,075.00	1	ЗГХЭГ	18,159,075.00	-
2	Төрийн албаны зөвлөл DZ-1992	21,277,300.00	2	Төрийн албаны зөвлөл	21,277,300.00	-
3	СЭЗЯ DZ-1992	21,277,300.00	3	Санхүү, эдийн засгийн яам	21,277,300.00	-
4	БСШУЯ DZ-1992	21,277,300.00	4	БСШУЯам	21,277,300.00	-
5	ҮХЯ DZ-1992	21,277,300.00	5	Үйлдвэр худалдааны яам	21,277,300.00	-
6	БХЯ DZ-1992	21,277,300.00	6	Үндэсний аудитын газар	21,277,300.00	-
7	Баянхонгор аймгийн Засаг дарга DZ-1992	24,395,525.00	7	Гадаад хэргийн яам	21,277,300.00	3,118,225.00
8	ЗГХЭГ DZ-1992	24,395,525.00	8	Хууль зүй дотоод хэргийн яам	21,277,300.00	3,118,225.00
9	Орхон аймгийн Засаг дарга DZ-1992	24,395,525.00	9	Байгаль орчны яам СТХ-ийн дарга	21,277,300.00	3,118,225.00
10	Төв аймгийн Засаг дарга DZ-1992	24,395,525.00	10	БХЯ	21,277,300.00	3,118,225.00
11	Төрийн албаны зөвлөл DZ-1992-1	18,159,075.00	11	Дэд бүтцийн яам, МХТ-ийн БЗГ-ын дарга	21,277,300.00	(3,118,225.00)
12	Төрийн албаны зөвлөл DZ-1992-2	18,159,075.00	12	НХХЯам	21,277,300.00	(3,118,225.00)
13	Увс аймгийн Засаг дарга DZ-1992	24,395,525.00	13	ХХААЯам	21,277,300.00	3,118,225.00
14	ХЗДХЯ DZ-1992	21,277,300.00	14	ЭМЯам	21,277,300.00	-
15	ХХААЯ DZ-1992	21,277,300.00	15	ТТХГазар	21,277,300.00	-
	Дүн	325,395,950.00			316,041,275.00	9,354,675.00